



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/346 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2013-2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийн нэмэлтээр орж ирсэн санхүүжилтаас цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээний төсвийг хавсралтаар баталсугай.

2. Шагналын санг нэмэгдүүлэхэд шаардагдах 5.706.000 /таван сая долоон зуун зургаан мянган/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2016 оны *Төв дугаар* сарын *11*-ны өдрийн
А.28 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт
гимнастикийн тэмцээний нэмэлт төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 33х 30.000 төг = 990.000 төг 2-р байр 33х 22.000 төг = 726.000 төг 3-р байр 60х 15.000 төг = 990.000 төг	2.706.000
2.	Багийн шагнал:	3.000.000
	ДҮН:	5.706.000

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг